

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 71

Төрийн ордон, Улаанбаатар хот

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН
НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, 57.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 40 хувиар тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР